

Говь-Алтай аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ид тод байдлын  
санаачилгын дэд зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

2024.02.15

Алтай хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зарцуул сан хөрөнгө	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)
<b>1.Судалгаа, мэдээ тайлан гаргах ажлын хүрээнд</b>					
1	Олборлох үйлдвэрлэлийн ид тод байдлын санаачилгын дэд зөвлөлийг шинэчлэх, төлөвлөгөө батлах, тайлан хэлэлцэх хурлыг зохион байгуулах	--	хурал хийгдсэн эсэх	2	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлийг аймгийн Засаг даргын 2023 оны А/172 дугаар захирамжаар шинэчлэн байгуулж, дэд зөвлөлийн хурлаар 2023 оны хийх ажлыг төлөвлөж, цаашид хэрхэн ажиллах талаар хэлэлцэв  Хэрэгжилт 100%
2	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн судалгааг дэд зөвлөлийн гишүүд, сумдад хүргүүлэх	---	Судалгааг сумдад хүргүүлэх	4	Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн судалгааг сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагчид болон холбогдох албан тушаалтнуудад 3 удаа хүргүүлж, мэдээллээр хангаж ажиллав.  Хэрэгжилт 100%
3	Орон нутагт хүлээн авсан татвар, төлбөр, хандив, дэмжлэгийн мэдээ тайланг аймгийн цахим хуудас дээр байршуулах	----	Цахим хуудсанд байршуулах	1	“Үйлдвэрлэлийн ил тод байдал-орон нутагт” илтгэл мэдээлэлд 2022 онд хайгуулын болон ашиглалтын лицензтэй аж ахуйн нэгжүүдийн мөнгөн болон мөнгөн бус хандивыг нэгтгэн мэдээлэв.  Хэрэгжилт 70%
4	Байгаль орчны нөхөн сэргээлттэй холбоотой мэдээ, тайлан гаргах	----	Нөхөн сэргээлтийн мэдээ гаргах	1	Хайгуул ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн 2023 оны байгаль орчны менежментийн 50 төлөвлөгөөг хүлээн авч хянасан бөгөөд 23.7 га газарт хийсэн техникийн нөхөн сэргээлт хийсэн байна.
5	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн хэрэгжилтийн мэдээ тайлан гаргах, гэрээний ил тод байдлын цахим санд шинээр байгуулсан	---	Нийгмийн хариуцлагын гэрээг	10	9 сум 12 аж ахуйн нэгжтэй Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор баталсан “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулах гэрээний загвар”-ын дагуу байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх,

	гэрээг www.iltodgeree.mn	оруулах-	<a href="http://www.iltodgeree.mn">www.iltodgeree.mn</a> оруулах		ажлын байр нэмэгдүүлэх гэрээ байгуулан, ажиллаж байгаа бөгөөд биелэлтийг 12 дугаар сарын 25-ны дотор гэрээ бүрийг <a href="http://www.iltodgeree.mn">www.iltodgeree.mn</a> эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд байршуулав.  Хэрэгжилт-100%
<b>2.Иргэдэд нээлттэй ил тод мэдээлэх, олон талын оролцоотой хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хүрээнд</b>					
1	2023 онд төвлөрүүлсэн татвар, төлбөр, хураамжийн орлогын тайланг байршуулах	---	Төвлөрүүлсэн бүх татвар хураамжийг цахимд байршуулах	1	Ашигт малтмал газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжээс 2022 онд орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хураамж, хандив тусламжийг тайлагнах ажлыг зохион байгуулж, 31 аж ахуйн нэгжийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн албан татвар, төлбөр, хураамж 220.7 сая, 17 аж ахуйн нэгжийн төрийн болон төрийн бус байгууллагат өгсөн хандив, тусламж 468.1 сая төгрөгийн орлогыг <a href="http://ereporting.eitimongolia.mn">ereporting.eitimongolia.mn</a> цахим системд оруулан нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулав.  Хэрэгжилт 100%
2	Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон томоохон арга хэмжээний үеэр мэдээлэл хийх		Мэдээлэл хийх	1 удаа	Хариуцлагатай уул уурхайн өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулах үеэр тус аймагт хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны талаарх сурталчилгааг нээлттэй явуулав. 1 аж ахуйн нэгжийн 2022 оны нийгмийн хариуцлагын гэрээний биелэлт, цаашид анхаарах асуудлын талаарх хэлэлцүүлгийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар болон холбогдох агентлагуудын удирдлагуудын дунд зохион байгуулав.  Хэрэгжилт 100%
<b>3.Хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, чадавхи бэхжүүлэх ажлын хүрээнд</b>					
1	Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах болон хууль тогтоомжийн хэрэгжилт цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зохион байгуулах сургалт арга хэмжээнд оролцох	----	Сургалт арга хэмжээнд хамрагдах	1-ээс доошгүй удаа	Монголын ОУЗСТ-ийн ажлын албанаас зохион байгуулсан “МОУИТБС-ын 2022 оны баталгаажуулалтын тайлангийн дүгнэлтийн хэлэлцүүлэг, орон нутгийн дэд зөвлөлүүдийн чадавх бэхжүүлэх” сургалтад зөвлөлийн 2 гишүүн хамрагдав.

					“Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал-орон нутаг” илтгэлийг баруун бүсийн уул уурхайн өдөрлөгийн үеэр тавьж хэлэлцүүлэв. Хэрэгжилт 100%
--	--	--	--	--	--

<b>Дундаж</b>					<b>93.8%</b>
---------------	--	--	--	--	--------------

ГЕОЛОИ УУЛ УУРХАЙН ХЯНАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ Д.ЭРХЭМБАЯР